

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 08 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2016 оны А/635 дугаар захирамжийн дагуу 2016 оны 08 дугаар сарын 31-ний өдөр үүсгэн байгуулагдсан бөгөөд нийслэлийн залуучуудад эерэг сэтгэлгээ, зөв хандлагыг төлөвшүүлэх, тэдний эрүүл амьдрах, сурч боловсрох, ажиллаж, хөдөлмөрлөх таатай орчинг бүрдүүлэх, хотын хөгжил, соёл, тохижилтод залуучуудын **нийгмийн** оролцоог нэмэгдүүлэх, залуучуудын хөгжил, **хамгааллын** хууль, тогтоомж, Монгол Улсын Засгийн газар, нийслэлийн Засаг даргын хөтөлбөрийг хэрэгжүүлж, **зохицуулах** чиг үүрэг бүхий залуучуудын асуудлыг дангаараа эрхлэх орон нутгийн төрийн захиргааны байгууллага юм.

Үндэсний статистикийн хорооны 2018 оны 09 дүгээр сарын байдлаар гаргасан тайлан **мэдээллээр** нийслэл Улаанбаатар хотод 1,462,973 иргэн байгаагаас 477,249 буюу нийслэлийн нийт хүн амын 35,3 хувийг 15-34 насны залуучууд эзэлдэг.

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар эдгээр залуучууд руу чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, эрүүл чийрэг, оюунлаг, бүтээлч залуус манлайлсан хот болгох зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар, дүүргүүдийн Залуучуудын хөгжлийн төв 2018 **оны эцсийн** байдлаар залуучууд руу чиглэсэн аян, чуулга уулзалт, хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн, сургалт нөлөөллийн олон талт үйл ажиллагаануудад давхардсан тоогоор нийт **265,922** залуучуудыг хамруулаад байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.1-т тусгасан "Нийслэлд залуучуудын талаар баримтлах бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 158 дугаар тогтоолоор **"Нийслэлийн Залуучууд"** дэд хөтөлбөрийг нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав.



Мөн нийслэлийн "Залуучуудын хөгжлийг дэмжих төв"-ийг 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдөр албан ёсоор нээв. Тус төвийн дэргэд БНСУ-ын Засгийн газрын агентлаг, Олон улсын хамтын ажиллагааны байгууллага "КОЙКА"-ын (KOICA) санхүүжилттэй төслийн гүйцэтгэгч "Эм Кэй Ай Ти" ("MKIT") сургалтын төвтэй хамтран

мэдээллийн технологийн нарийн мэргэжил олгох сургалт зохион байгуулан, /тус төвийн сургалтыг/ амжилттай төгсөгчдийг “Бизнес инкубатор төв”-өөр цалинтай дадлагажуулж, залуучуудын амралт чөлөөт цагийг зөв, боловсон, үр дүнтэй өнгөрүүлэх зорилгоор 12 хобби клубүүд байгуулан, үйл ажиллагааг нь өргөжүүлсээр байна.

Нийслэлийн “Залуучуудын хөгжлийг дэмжих төв”-ийн дэргэдэх Мэдээллийн технологийн сургалтын төвд 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл нийт 2,638 залуучууд суралцах хүсэлтээ өгч, бүртгүүлсэн бөгөөд сургалт явуулах орчны хүртээмжээс хамааран 1,890 залуучуудыг мэдээллийн технологийн сургалтын төвд хамруулан 646 нь амжилттай төгсөж, 20 иргэнийг инкубатор төвөөр дамжуулан бойжуулж, 45 залуучуудыг ажлын байранд холбон зуучилж байсан бол 2018 онд нийт 8475 залуучууд суралцах хүсэлтээ өгч, бүртгүүлсэн бөгөөд сургалт явуулах орчны хүртээмжээс хамааран 1366 залуучуудыг мэдээллийн технологийн сургалтын төвд хамруулан 834 нь амжилттай төгсгөсөн байна.

Үүнээс дүгнэхэд залуучууд Нийслэлийн “Залуучуудын хөгжлийг дэмжих төв”-ийн дэргэдэх Мэдээллийн технологийн сургалтын төвийн үйл ажиллагааг залуучууд мэдэж, суралцах хүсэл эрмэлзлэл бий болсон нь харагдаж байна.

Эерэг сэтгэлгээ, зөв хандлага төлөвшүүлэх “Эерэг амьдарцгаая залуучууд аа!” аян, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад чиглэсэн “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аян, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх “Орлоготой залуучууд” аян, биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийнгээ орчноо цэвэрлэх “Гүйе!, Түүе!” аян, нийслэлийн хөгжил, тохижилтыг сайжруулахад залуучуудын идэвх, оролцоог нэмэгдүүлэх, ногоон орчин бий болгох “Ногоон орчин–Эрүүл амьдрал” аяныг тус тус санаачлан зохион байгууллаа.

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Нийслэлийн Залуучууд” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2018 онд 26 томоохон үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 17 ажлыг хийж гүйцэтгэлээ. 2017-2018 онуудад нийт 44 томоохон үйл ажиллагааг 311 удаагийн давтамжтай зохион байгуулж, давхардсан тоогоор 245,592 залуучуудыг хамруулав. Мөн 311 үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг 15-25 хэвлэл мэдээллийн хэрэгслээр 4,665 удаагийн давтамжтай, төсвийн зарцуулалтгүйгээр олон нийтэд түгээв.



НИЙСЛЭЛИЙН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРААС ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ БОЛОВСРУУЛАХАД ТУСГАСАН САНАЛ, ОРОЛЦООНЫ ТАЛААР

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль

Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилго бүхий Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр УИХ-ын чуулганаар батлагдаж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Тус хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын дарга С.Сүх-Очир оролцож, залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд баримтлах зарчим, залуучуудын хөдөлмөр эрхлэлт болон аюулгүй ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд санал тусгах чиглэлээр ажилласан.

“Нийслэлийн залуучууд” дэд хөтөлбөр

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.1 дэх зорилтын хүрээнд “Нийслэлийн Залуучууд” дэд хөтөлбөрийн төслийг боловсруулж, эхний шатны хэлэлцүүлгийг 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдөр 200 залуучуудын оролцоотойгоор нийслэлийн Иргэний танхимд зохион байгуулав. Тус хэлэлцүүлэгт залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, нийслэлийн 9 дүүргийн иргэдийн төлөөлөл, нийслэлийн харьяа агентлагуудын холбогдох мэргэжилтнүүд оролцсон бөгөөд Хоёр дахь удаагийн хэлэлцүүлгийг 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Монголын хүүхдийн ордонд 500 залуучуудын оролцоотойгоор зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгээс гарсан санал, санаачилгыг нэгтгэн “Нийслэлийн Залуучууд” дэд хөтөлбөрт тусгаж, 6 бүлэгтэйгээр боловсруулан 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 158 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна.

“Нийслэлийн залуучууд” дэд хөтөлбөр гурван үе шаттай, 2020 он хүртэл хэрэгжих бөгөөд залуучуудын боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, залуучуудад ээлтэй орчин бүрдүүлэх, тэдний оролцоог дэмжих асуудлыг цогцоор нь багтаасан болно.

“Нийслэлийн Залуучууд” дэд хөтөлбөр батлагдсанаар нийслэлд анх удаа залуучуудад иргэний ёс суртахууныг төлөвшүүлэх, авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийн орчин нөхцөлийг сайжруулж, нийслэлийн хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтод залуучуудын санаачилга, оролцоог дэмжих тогтолцоог бүрдүүлэх, эрүүл чийрэг оюунлаг, бүтээлч, залуус манлайлсан хот болгох бодлогын баримт бичигтэй болсон юм.

“Нийслэлийн Залуучууд” дэд хөтөлбөрийн үндсэн зорилт:

1. Залуучуудын бодит оролцоог нэмэгдүүлж, эерэг хандлагатай бүтээлч иргэн болгон хөгжүүлэх,
2. Залуучуудыг эрүүл амьдралын хэв маягт төлөвшүүлж, гэр бүлийн боловсрол олгож, амьдрах ухааны мэдлэг чадварыг эзэмшүүлэх,
3. Залуучуудад нарийн мэргэжил эзэмших ач холбогдлыг ойлгуулах сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах,
4. Залуучуудын амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх хөгжлийн орчин үйлчилгээг шинээр нэвтрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх үндсэн 4 зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Мөн нийслэлийн 9 дүүрэгт Залуучуудын хөгжлийн төвүүд тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс **2018 оны эцсийн байдлаар** олон талт үйл ажиллагаа зохион байгуулж, нийт **80,962** залуучуудыг хамруулав.

Монгол Улсын Засгийн газрын “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”

Монгол Улсын Засгийн газрын 42 дугаар тогтоолоор 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжүүлэх бодлогын баримт бичигт залуучуудын эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх талаар санал хүргүүлж, залуучуудын амьдралын чанарыг дээшлүүлэх, байнгын ажлын байртай болгох замаар ядуурлыг бүр мөсөн устгах бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Тухайлбал “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын хүрээнд 2017-2018 онд иргэдийн орлого, амьдралын чанарыг нэмэгдүүлэх зорилгоор залуучуудад чиглэсэн “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт”, “Хөгжлийн хөтөч”, “Мэдээлэл

технологийн салбарт мэргэшсэн залуучуудыг цагийн болон тогтвортой ажлын байранд зуучлах хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг”, “Орлоготой залуучууд-мэргэшсэн жолооч”, “Эх орондоо хөдөлмөр эрхэлцгээе”, “Хөдөлмөрч залуучууд” болон “Ажлын туршлагагүй ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан” хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг зэрэг 7, сургалт 11 нийт 18 үйл ажиллагаа зохион байгуулж, 5,480 ажлын байр зарлаж, 2,084 залуучуудыг хамруулсан бөгөөд 1025 залууд зөвлөгөө мэдээлэл өгч, 136 залууг ажлын байранд холбон зуучилсан.

Замын хөдөлгөөний дүрэм шинэчлэн батлах тухай

“Дүрэм шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газраас сургууль орчмын замын хөдөлгөөний хэсгийг бүрэн камержуулах, сургууль орчмын бүсийн замын хөдөлгөөний хэсгийн гарц, гармын хэсэгт 5-аас доошгүй метрийн зайтай олон улсын стандартын дагуу хурд сааруулагчийг заавал байршуулах, сургууль орчмын хараа хяналтыг сайжруулах зорилгоор хичээлийн цагуудад “School police”-оос гадна урамшуулалт эргүүлийг байнга ажиллуулах, гарц гармын хэсэгт “Анхаар хүүхэд”, “Хурдны дээд хязгаар 10” гэсэн тэмдэг тэмдэглэгээг заавал байршуулах, сургууль орчмын бүсийн хэмжээг 300 метрээс доошгүйгээр тогтоох, хороолол дотор гүйцэж түрүүлэх үйлдэл хийхийг хориглохоос гадна сургууль орчмын бүсийн зам дээр гүйцэж түрүүлэх үйлдэл хийхийг хориглох, хороолол дотор дуут дохио ашиглахыг хориглосон тэмдэг, тэмдэглэгээг зайлшгүй байршуулах, зэрэг саналыг боловсруулан хүргүүлэв.

“Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтууруулахтай тэмцэх тухай” хууль

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтууруулах тухай” хуулийн төсөлд хурууны хээг ашиглан архи, согтууруулах ундаа худалдаалахад хяналт тавих болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан борлуулахад анхаарах асуудлын талаар санал хүргүүлсэн. “Хуулиа мөрдье +21” нөлөөллийн үйл ажиллагааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран хэрэгжүүлж, нийслэлийн хэмжээнд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж, нийт 67,000 ширхэг санамж, зөвлөмж, зурагт хуудас тараан байршуулж, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаанд 5,675 аж ахуйн нэгж байгууллага, 98,762 иргэнийг хамруулан ажиллав.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөр

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газраас “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” нийслэлийн дэд хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бүлгийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, худалдан борлуулах,

тэдний бодит оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг сургалт, нөлөөллийн ажлуудад хамруулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх талаар санал хүргүүлсэн.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛСАН ХӨДӨЛМӨРИЙН ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.7.1-т “Нийслэлийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 60 хувьд хүргэнэ”, 4.7.5. “залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг дэмжин, ажил олгогч, ажил хайгч иргэдэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг нэг цэгээс үзүүлнэ”, “Нийслэлийн Залуучууд” дэд хөтөлбөрийн 3.2.8-т “Зорилтот бүлгийн залуучуудад хөдөлмөр эрхлэх таатай боломжоор хангахад дэмжлэг үзүүлэх аян өрнүүлэх” зорилтууд тусгагдсан.



Дээрх зорилтуудын хүрээнд нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар санаачлан нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, “Монголын тэргэнцэртэй иргэдийн Үндэсний холбоо” ТББ, “Монголын Сонсголгүй иргэдийн байгууллагуудын

нэгдсэн холбоо” ТББ-тай хамтран “Хөдөлмөрч залуучууд” ажлын туршлагагүй залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөдөлмөрийн үзэсгэлэн яармагийг 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд зохион байгуулав.

Ажил идэвхтэй хайж байгаа хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг сурган ажлын байранд холбон, ажилд ороход шаардлагатай зөвлөн туслах үйлчилгээнд хамруулж, аж ахуй нэгж, байгууллагад холбох зорилгоор “Хөдөлмөрч залуучууд” хөдөлмөрийн үзэсгэлэн яармагт “Карьер хөгжлийн төв”, “ORP” институт, Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн оролцож, үйл ажиллагааны чиглэлийнхээ дагуу ажил хайгч иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.

Тус үйл ажиллагааны үеэр нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлуулах боломжтой 115 ажлын байр зарлагдаж, “Монголын тэргэнцэртэй иргэдийн Үндэсний холбоо” ТББ, “Монголын Сонсголгүй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоо” ТББ-ын төлөөллүүд болон нийт 30 гаруй хөгжлийн бэрхшээлтэй залуучууд оролцсон юм.



И

ргэ

д ажлын байранд бүртгүүлэн, анкет бөглөж, хөдөлмөрийн үзэсгэлэн яармагт хүрэлцэн ирсэн байгууллагуудын хүний нөөцийн менежерүүдтэй уулзаж, ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдав.

Энэхүү хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг нь хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийслэлийн хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах зорилгоор төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран, хувийн хэвшлийнхний оролцоотойгоор зохион байгуулав.



Үйл

ажиллагаанд

оролцсон ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагуудын жагсаалт:

- “Таван богд групп” ХХК
- “Ич крем” ХХК
- “Эргэл хас” ХХК
- “Кашмер холдинг” ХХК
- “Траст трейд” ХХК
- “Монхангай групп” ХХК
- “М Жи Си стар групп” ХХК
- “Хөгжил трейд” ХХК
- Соёл велнес төв
- “Алтангадас трейд” ХХК

- “Ханбүргэдэй” ХХК
- Тесо Корпораци
- “Арж капитал” ХХК
- “Номин холдинг” ХХК
- “Нэкст групп” ХХК
- “Бишрэлт Трейд” ХХК
- “Тоба маркет” ХХК
- “Сэрж Интернэшнл” ХХК
- “Бишрэлт пропертис” ХХК
- “Транс капитал” ББСБ
- “ZIP сервис” ХХК
- “Наран трейд” ХХК
- “Монголын алт групп” ХХК

“Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай” хууль

УИХ-ын гишүүн Д.Оюунхоролын санаачилсан “Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын дарга С.Сүх-Очир, Захиргааны хэлтсийн дарга Н.Мандуул, эрх зүй, дотоод аудит, хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Н.Амарбаясгалан нар орж ажиллалаа.

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газраас сайн дурын үйл ажиллагааны төрлийг нарийвчлан оруулах, гадаад дотоодын их, дээд сургуульд элсэн суралцахад сайн дурын үйл ажиллагаа санаачилсан, зохион байгуулсан, оролцсон талаар шалгуур үзүүлэлттэй болох, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулинд заасан сайн дурын үйл ажиллагаатай холбоотой заалтуудаас нэмэлт оруулах санал боловсруулан хүргүүлсэн.

НИЙСЛЭЛИЙН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨВ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөрт оюутан залуучуудыг тогтвортой ажлын байраар хангах, нарийн мэргэжил эзэмшүүлэх цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулах зорилт тусгагдсаны дагуу Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага “КОЙКА”-ийн (КИОСА) санхүүжилттэй төслийн гүйцэтгэгч “Эм Кэй Ай Ти” сургалтын төвтэй хамтран “Нийслэлийн залуучуудын хөгжлийг дэмжих төв”-ийн дэргэдэх мэдээллийн технологийн сургалтын төвийг 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр албан ёсоор нээж, тус төвийн дэргэд “Мэдээллийн технологийн сургалтын төв”, “Бизнес инкубатор төв”, “Залуучуудын сонирхлыг дэмжих хобби клуб”, “Нийслэлийн залуучуудын сайн дурын төв”-ийг байгуулан, залуучууд руу чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаануудыг тогтмол зохион байгуулж, “Нийслэлийн Залуучууд” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Мэдээллийн технологийн сургалтын төв” нь мэдээллийн технологийн чиглэлээр нийслэлийн залуучуудыг богино хугацаанд мэргэшүүлэн сургаж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай боловсон хүчин бэлтгэх, Монгол Улсын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дэлхийн түвшинд хүргэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор компьютерын өргөн хэрэглээний программын сургалтаас гадна “JAVA” хөгжүүлэгч, вэб хөгжүүлэгч, вэб дизайн, системийн зохицуулагч, өгөгдлийн сан болон фотошоп программын анхан шат, “excel” программын ахисан түвшний нарийн мэргэжлийн 8 төрлийн сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулж байна.

Мэдээллийн технологийн сургалтын төв нь 76 компьютер, 4 сургалтын танхим, “Бизнес инкубатор төв”-өөс бүрддэг.



Сургалтын танилцуулга:

1. Үндсэн хэрэглээ:

Нэг сарын хугцаанд хичээллэж байгаа бөгөөд долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гаргуудад 18:30-19:50-ийн хооронд хичээллэж байна.

2018 оны байдлаар нийт 785 хүн бүртгүүлсэн бөгөөд үүнээс 754 хүн үндсэн хэрэглээний ангид хамрагдан 529 хүн төгсөж батламж гардан авсан байна.

2. Фотошоп программын анги:

Фотошоп программын анги нь нэг сарын хугцаатай хичээллэдэг бөгөөд долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гаргуудад 18:30-19:50-ийн хооронд хичээллэж байна.

2018 оны байдлаар нийт 125 хүн бүртгүүлсэн бөгөөд 125 хүн фотошоп программын ангид хамрагдан үүнээс 56 залуучууд төгсөж батламж гардан авсан байна.

3. Жава хөгжүүлэгчийн анги:

Жава хөгжүүлэгчийн анги нь 4-н сарын хугацаанд хичээллэдэг бөгөөд нийт бүртгүүлсэн хүмүүсээс IQ болон англи хэлний шалгалт авч тэнцсэн хүмүүсийг шалгаруулан авдаг. Энэхүү анги нь долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гаргуудад 10-14:30-ийн хооронд хичээллэж байна.

2018 оны байдлаар жава хөгжүүлэгчийн ангид нийт 2481 хүн бүртгүүлсэн бөгөөд 115 хүн хамрагдаж 63 хүн төгсөн батламжаа авсан байна.

4. Вэб хөгжүүлэгчийн анги:

Вэб хөгжүүлэгчийн анги нь 4-н сарын хугацаанд хичээллэдэг бөгөөд нийт бүртгүүлсэн хүмүүсээс IQ болон англи хэлний шалгалт авч тэнцсэн хүмүүсийг шалгаруулан авдаг. Энэхүү анги нь долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гаргуудад 10-14:30-ийн хооронд хичээллэж байна.

2018 оны байдлаар вэб хөгжүүлэгчийн ангид нийт 2481 хүн бүртгүүлсэн бөгөөд 127 хүн хамрагдаж 65 хүн төгсөн батламжаа авсан байна.

5. Вэб дизайны анги:

Вэб дизайны анги нь 4-н сарын хугацаанд хичээллэдэг бөгөөд нийт бүртгүүлсэн хүмүүсээс IQ болон англи хэлний шалгалт авч тэнцсэн хүмүүсийг шалгаруулан авдаг. Энэхүү анги нь долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гаргуудад 10-12:30-ийн хооронд хичээллэж байна.

2018 оны байдлаар вэб дизайны ангид нийт 2481 хүн бүртгүүлсэн бөгөөд 123 хүн хамрагдаж 45 хүн төгсөн батламжаа авсан байна.

6. Системийн зохицуулагчийн анги:

Системийн зохицуулагчийн анги нь байгууллагын захиалгаар хичээллэдэг бөгөөд долоо хоног бүрийн Мягмар Пүрэв гаргуудад 18-20цагийн хооронд хичээллэж байна.

2018 оны байдлаар системийн зохицуулагчийн ангид нийт 32 хүн бүртгүүлсэн бөгөөд 32 хүн хамрагдаж 20 хүн төгсөн батламжаа авсан байна.

7. Өгөгдлийн сангийн зохицуулагчийн анги:

Өгөгдлийн сангийн зохицуулагчийн анги нь байгууллагын захиалгаар хичээллэдэг бөгөөд долоо хоног бүрийн Даваа, Лхагва гаргуудад 18-20цагийн хооронд хичээллэж байна.

2018 оны байдлаар өгөгдлийн сангийн зохицуулагчийн ангид нийт 28 хүн бүртгүүлсэн бөгөөд 28 хүн хамрагдаж 17 хүн төгсөн батламжаа авсан байна.

8. Солонгос хэл:

Солонгос хэлний анги нь 4-н сарын хугцаанд хичээллэж байгаа бөгөөд долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гаргуудад 13-14:30-ийн хооронд хичээллэж байна.

2018 оны байдлаар мэргэжлийн ангиас солонгос хэл сонгон суралцсан хүсэлт гаргасан 62 хүнээс 62 хүн хамрагдаж 39 хүн төгсөн батламжаа авсан байна.

Ахисан түвшний анги:

Энэхүү ангийг 2018 оноос анх удаагаа туршилтаар нээн хичээллэж байгаа бөгөөд жава болон вэб хөгжүүлэгчийн чиглэлээр урд нь сурч байсан, мөн манай байгууллагаас явуулдаг сургалтад хамрагдаж байсан залуучуудаас шалгалт авч тэнцсэн залуучуудыг хамруулан хичээллүүлж байгаа бөгөөд суралцаж байх хугацаандаа сар бүр 220.000₮-ний тэтгэлэг аван суралцах боломжтой юм. Мөн энэхүү ангийг амжилттай төгссөн залуучуудыг ажлын байранд шууд холбон зуучлахаар төлөвлөн ажиллаж байна.

Ахисан түвшний анги нь долоо хоног бүрийн Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан гаргуудад 10:00-17:30 цагийн хооронд хичээллэж байна. Одоогийн байдлаар 18 хүн хамрагдан суралцаж байгаа.

Бизнес инкубатор төвийн танилцуулга:

Тус сургалтыг амжилттай төгссөн суралцагчид Бизнес инкубатор төвд хамрагдах боломжтой бөгөөд тус төвд элссэн дадлагажигчид сар бүр 440.000₮-ний тэтгэлэг авдаг Инкубатор төвд элсэгчид Даваа-Баасан гарагуудад 08:00-18:00 цагуудын хооронд өөрийн бизнес төслөө хэрэгжүүлэхийн хажуугаар гадаадаас ирүүлсэн аутсорсинг захиалгын гүйцэтгэх ажлууд дээр дадлага хийж байна.

Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор тус төвийг нээсэн бөгөөд “Нийслэлийн Залуучуудын хөгжлийг дэмжих төв”-ийн дэргэдэх мэдээллийн технологийн сургалтын төвийн мэргэжлийн ангийг “А” үнэлгээтэй төгссөн залуучууд “Бизнес инкубатор төв”-д шууд элсэж, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжтой юм.

“Бизнес инкубатор төв”-д бойжиж байгаа залуучуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулдаг бөгөөд 2018 **оны 07 дугаар сарын байдлаар 20** иргэнд нийт **8,800,000** төгрөгийн тэтгэлэг олгосон байна. “Бизнес инкубатор төв”-д бойжиж байгаа иргэдэд сар бүр 440,000 төгрөгийн тэтгэлгийг БНСУ-ын КОЙКА-ын төслийн санхүүжилтээс олгодог юм.



2018 онд нийт 8475 залуучууд суралцах хүсэлтээ өгч, бүртгүүлсэн бөгөөд сургалт явуулах орчны хүртээмжээс хамааран 1366 залуучуудыг мэдээллийн технологийн сургалтын төвд хамруулан 834 нь амжилттай төгсгөсөн байна.

Мөн гадаад хэлний мэдлэг олгох, мэдээлэл технологийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ болон гадаад, дотоодын байгууллагуудыг “IT”-ийн боловсон хүчнээр хангаж, гадаадын аж ахуй нэгжүүдээс аутсорсингийн захиалга авч, гүйцэтгэлээр хангах үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ мэдээллийн технологийн хөгжилд шинэлэг, шилдэг технологийг нэвтрүүлэхийг зорин веб сайтын цогц үйлчилгээг нэвтрүүлж, эх орондоо хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж байна. Тус сургалтын төвд хамрагдан амжилттай төгссөн залуучууд эх орондоо хөдөлмөр эрхэлж, гадны орнуудаас ажлын захиалга аван, өндөр цалинтай ажиллах нөхцөл боломжоор хангагдаж байгаа юм.

Тус сургалтын төвд **2018 оны байдлаар нийт 1366 залуучуудыг** хамруулсан бөгөөд сургалтын төлбөрийг зах зээлийн ханшаар тооцвол **341,500,000** төгрөгийн төсвийн хэмнэлт гаргасан байна.



3. Залуучуудын сонирхлыг дэмжих хобби клубүүд:

“Нийслэлийн Залуучуудын хөгжлийг дэмжих төв”-ийг түшиглэн Нийслэлийн Засаг даргын А/547 дугаар захирамжийн дагуу нийслэлийн төсвийн хөрөнгөөр залуучуудын авьяас чадварыг хөгжүүлэх, мэдлэг мэдээллээр хангах, уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, санаачилгатай, бүтээлч, нийгмийн идэвхтэй, мэргэжилдээ эзэн болсон залуучуудыг нэгтгэх, нэмэгдүүлэх, залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор сайн дурын хобби клубүүдийг 2017 оны 7 дугаар сарын 17-ны өдрөөс нээн ажиллуулж байна.

Нийт 12 сонирхлын сайн дурын клубүүдэд нэгдэх хүсэлтэй залуучуудыг бүртгэн үйл ажиллагаагаа эхлүүллээ.

Тухайлбал:

1. Номонд дурлагсдын клуб

2. Гадаад хэл сонирхогчдын клуб
3. Кино урлаг сонирхогчдын клуб
4. Илтгэх ур чадвараа хөгжүүлэх залуучуудын клуб
5. Уран зураг сонирхогчдын клуб
6. Орчуулагчдын клуб
7. Бизнес эрхлэгч залуучуудын клуб
8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих клуб
9. Шатар сонирхогчдын клуб
10. Бүжиг сонирхогчдын клуб
11. Сайн дурын клуб
12. “Залуу сэтгүүлч” зэрэг клубүүд ажиллаж байгаа бөгөөд цаашид клубүүдийн тоог нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

“ЭЭРЭГ АМЬДАРЦГААЯ ЗАЛУУЧУУД АА!” АЯН

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.2-т "Залуучуудыг хотын соёл суралцуулах, соён гэгээрүүлэх, чөлөөт цагийн орчин нөхцөлийг сайжруулах" зорилтын хүрээнд залуучуудад эерэг сэтгэлгээ, зөв хандлага төлөвшүүлэх, нийгмийн сэтгэлзүйд давамгайлсан сөрөг уур амьсгалыг эерэг болгох зорилгоор нийслэлийн 9 дүүрэгт **“ЭЭРЭГ АМЬДАРЦГААЯ ЗАЛУУЧУУД АА!”** аян зохион байгуулж, 2017 онд 16,500, 2018 оны **10 дугаар сарын 30**-ны өдрийн байдлаар 21,950 нийт 38,450 залуучуудыг хамруулан ажиллав.

ЕБС-ийн сурагчдад зориулсан эерэг сэтгэлгээ, зөв хандлага төлөвшүүлэх сургалт

“Эерэг амьдарцгаая залуучууд аа!” аяны хүрээнд эерэг сэтгэлгээ, зөв хандлага төлөвшүүлэх сургалтыг Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол, Чингэлтэй болон Багахангай дүүрэгт 2017 онд 22 удаагийн сургалт зохион байгуулж ЕБС-ийн ахлах ангийн 4,831 сурагч, 2018 онд 25 удаагийн сургалт зохион байгуулж, 5169 сурагчийг хамруулж нийт 47 удаагийн сургалтад ЕБС-ийн ахлах ангийн 10,000 сурагчийг хамруулав.



“НИЙСЛЭЛИЙН ЗАЛУУЧУУДЫН 10 ЗӨВ ДАДАЛ” АЯН

Нийслэлийн иргэний дагаж мөрдөх 10 зөв дадлыг олон нийтийн хандлага, саналд үндэслэн боловсруулж, Нийслэл Улаанбаатар хотын 9 дүүргийн 152 хорооны иргэд, ЕБС-ийн сурагчид, их, дээд сургуулийн оюутан залуучуудад 10 зөв дадлыг сурталчлан таниулах ажлыг 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 10 удаагийн сургалт зохион байгуулж 5,827, нийт 210 удаагийн сургалтад 41,762 иргэдийг хамруулсан.



1. Нийслэлийн иргэний 10 зөв дадал сургалт

Нийслэлийн иргэний дагаж мөрдөх 10 зөв дадлыг сурталчлан таниулах сургалтыг 200 удаа зохион байгуулж, нийслэлийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, их, дээд сургууль, МСҮТ-ийн оюутнууд, төр болон хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчид, нийслэлийн 152 хорооны иргэдийн төлөөлөл зэрэг нийт 18,015 иргэнийг хамруулав.



2. Нийслэлийн иргэний 10 зөв дадлыг сурталчилсан хэлбэр:

Нийслэлийн иргэний дагаж мөрдөх 10 зөв дадлыг өөртөө хэвшүүлээгүй ба хэвшүүлсэн иргэн, тэдгээрийн ялгааг харуулсан 8 шторк хийж, цахим сүлжээнд байршуулсан.

Шторк бүр дунджаар 30 секунд үргэлжлэх ба крилл болон уйгаржин монгол бичгээр тайлбар оруулав. Энэхүү бичлэгийг цахим сүлжээнд байршуулснаас хойш одоог хүртэл нийт 5,935 удаагийн хандалт авсан байна.

3. Нийслэлийн иргэний 10 зөв дадлын тухай зурагт хуудас

Нийслэлийн иргэний дагаж мөрдөх 10 зөв дадлын тухай “А4” хэмжээтэй зурагт хуудас боловсруулж, сургалтад оролцсон 10,000 иргэнд түгээв.

“ИРЭЭДҮЙН ЭЗЭД” МЭРГЭЖИЛ СОНГОЛТЫН АЯН

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, дүүргүүдийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс болон Боловсролын хэлтэс, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аяныг 2017-2018 онуудад зохион байгууллаа.

Аяны хүрээнд 2018 онд нийслэлийн хэмжээнд 12,960, нийт 29,277 ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг хамруулсан байна.

Боловсролын хүрээлэнгээс хийсэн судалгаанаас үзэхэд нийт ахлах ангийн сурагчдын 82.2 хувь нь мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт мэдээлэл хэрэгтэй байна гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд мэргэжил сонголтын талаарх мэдээ, мэдээлэл сурагчдад нэн шаардлагатай болохыг харуулж байгаа тул “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аяныг жил бүр

уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөөд байна.



ОРЛОГОТОЙ ЗАЛУУЧУУД АЯН

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар, Монгол Улсын тээврийн салбарт тэргүүлж буй үндэсний 17 компанийн гишүүнчлэлтэй “Монгол Тээвэр Нэгдэл” ХХК-тай залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, тогтвортой ажлын байраар хангах зорилгоор хамтын ажиллагааны санамж бичгийг 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдөр байгуулав.

Санамж бичгийг нэг талаас нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын дарга С.Сүх-Очир, нөгөө талаас “Монгол Тээвэр Нэгдэл” ХХК-ийн ТУЗ-ийн дарга бөгөөд ерөнхийлөгч С.Ганболд нар үзэглэв.

Энэхүү санамж бичгийн хүрээнд “Монгол Тээвэр Нэгдэл” ХХК-ийн гишүүн 17 компанид уул уурхай, орон нутаг, хот хоорондын тээвэр, транзит болон зорчигч тээврийн чиглэлээр эхний ээлжид С,Е ангиллын жолооны үнэмлэхтэй, мэргэшсэн жолоочийн 80 ажлын байр зарлагдсан бөгөөд тус ажлын байрны сонгон шалгаруулалтыг нийслэлийн Залуучууд хөгжлийн газар, “Монгол Тээвэр Нэгдэл” ХХК-тай хамтран зохион байгуулсан.




Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар тус ажлын байранд бүртгүүлсэн залуучуудыг эерэг хандлага төлөвшүүлэх, ажилдаа хариуцлагатай хандах, хорт зуршлаас ангид байх сургалт, нөлөөллийн ажлуудад хамруулж, амжилттай суралцсан залуучуудыг ажлын байранд холбож өгсөн юм.

“Монгол Тээвэр Нэгдэл” ХХК нь БНХАУ-ын “Чалко” компанитай 2018 оны 01 дүгээр сараас 2022 он хүртэл хамтын ажиллагааны тогтвортой байдлын гэрээ байгуулан ажиллаж байгаа юм. Нээлттэй ажлын байранд шинээр орох залуучуудын нэг сарын үндсэн цалин 1,5 сая төгрөгөөс 2 сая төгрөг хүртэл бөгөөд жолоочийн идэвх, зүтгэлээс хамааран цалингийн хэмжээ нэмэгдэх боломжтой.

Цаашид тээврийн салбартаа тэргүүлэгч “Монгол тээвэр нэгдэл” ХХК-д гишүүнчлэлтэй 17 компаниудад ажиллах хүсэл сонирхолтой 21-ээс дээш насны 1000 хүртэлх залуучуудыг тогтвортой ажлын байранд холбож өгөхөөр төлөвлөн ажиллаж байна.

Хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг

“Аялал жуулчлал ба ажил эрхлэлт” хөдөлмөрийн үзэсгэлэн яармагийг 2018 оны 04-р сарын 13-ны өдөр Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон “Монголын Оюутны холбоо” ТББ-тай хамтран зохион байгуулж, 40 гаруй аж ахуйн нэгж оролцон, 500 гаруй нээлттэй ажлын байр зарлав.



Мөн энэ үеэр жуулчны идэвхтэй улирал эхэлж байгаатай холбогдуулан гадаадын иргэд, жуулчдад нийслэл Улаанбаатар хот, Монгол улсынхаа түүх соёлыг сурталчлах, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлж, хотын үзвэр, үйлчилгээ, гудамж, талбайд аялах, зорчих үед нь мэдээллээр хангаж, гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлж, аюулгүй байдлыг хангах зорилготой “Оюутан цагдаа” хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудыг бүртгэсэн юм.

Гадаадын жуулчны хөтөч бэлтгэх сургалт

2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 19-ний өдрийн хооронд Залуучуудыг аялал жуулчлалын салбарт хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, гадаадын жуулчдад үйлчлэх аяллын хөтчийн талаарх анхан шатны мэдлэг олгох сургалтыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар болон Аялал жуулчлалын газар хамтран нийслэлийн Иргэний танхимд 2 дахь жилдээ зохион байгууллаа.



Тус сургалтад хөтөч болох сонирхолтой 205 залуучууд хамрагдсан бөгөөд ирцээ бүрэн хангаж, сургалтыг амжилттай дүүргэсэн 145 залуучуудад батламж гардуулав.



“ХӨДӨЛМӨРЧ ЗАЛУУЧУУД” ХӨДӨЛМӨРИЙН ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.4-т “Оюутан залуучуудыг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, тогтвортой ажлын байраар хангах, нарийн мэргэжил эзэмшүүлэх цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулна”, “Нийслэлийн Залуучууд” дэд хөтөлбөрийн 3.2.8-т “Зорилтот бүлгийн залуучуудад хөдөлмөр эрхлэх таатай боломжоор хангахад дэмжлэг үзүүлэх аян өрнүүлэх” зорилтууд тусгагдсаны дагуу хүрээнд нийслэлийн Залуучуудын хөгжлийн газраас санаачлан нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, “Монголын тэргэнцэртэй иргэдийн Үндэсний холбоо” ТББ, “Монголын Сонсголгүй иргэдийн нэгдсэн холбоо” ТББ-уудтай хамтран 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр 10:00-17:00 цагийн хооронд нийслэлийн Хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих төвд “Хөдөлмөрч залуучууд” хөдөлмөрийн үзэсгэлэн яармагийг зохион байгууллаа.



Тус хөдөлмөрийн үзэсгэлэн яармагийн үеэр нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд бүртгэлтэй 2300 гаруй ажлын байранд ажил хайж байгаа ажлын туршлагагүй залуучуудыг холбож өгөхөөс гадна салбартаа тэргүүлэгч 20 аж ахуй нэгж, байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ажлын байрыг нээлттэй зарлав.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх хэсэгт “25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна” гэж заасны дагуу тус хуулийн хэрэгжилтийг хангахаар төрийн болон төрийн бус байгууллагуудыг уриалахад энэхүү хөдөлмөрийн үзэсгэлэн яармагийн зорилго оршиж байна. Энэхүү хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг нь ажлын туршлагагүй залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийслэлийн хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангаж байгаагаараа онцлог юм.

“Хөдөлмөрч залуучууд” хөдөлмөрийн үзэсгэлэн яармагийг төрийн болон төрийн бус байгууллагуудын түншлэл дээр тулгуурлан зохион байгуулсан бөгөөд мэргэжлийн байгууллагуудаас ажлын туршлагагүй залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэтгэлзүйн болон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, мэдээллийг үнэ төлбөргүй өгөв.

Цаашид талуудтай хамтран ажлын туршлагагүй болон ажлын туршлагатай залуучуудад зориулсан томоохон хэмжээний хөдөлмөрийн үзэсгэлэн яармагийг тогтмол зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Ногоон орчинг хэрхэн бий болгох вэ? сургалт

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар “Ногоон хөгжил, цэвэр агаар-нэг мод хөдөлгөөн” ТББ-тай хамтран бүтээлч хөдөлмөрт оролцох хүсэлтэй залуучуудыг иргэдийн сайн дурын нөхөрлөл дээр тулгуурлан ногоон байгууламжийг бий болгох, цэцэрлэг, амралт зугаалгын газрыг тохижуулах, мод, бут, сөөгийг тарьж, арчлан ургуулах талаар мэргэшүүлэх сургалтыг 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Нийслэлийн засаг захиргааны V байрны сургалтын танхимд зохион байгууллаа.

Тус сургалтад хамрагдсан 30 иргэн сертификат гардан авч, суралцсан чиглэлээрээ түр ажлын байраар хангагдаж ажиллав.

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд байгаль орчноо нөхөн сэргээх, зохистой ашиглах, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг иргэдэд таниулан, мэдээлэл түгээж ажилладаг бөгөөд Нийслэлийн ЕБС-уудын сурагчид, их, дээд сургуулийн оюутан, залуучуудын экологийн боловсролыг сайжруулах, хүрээлэн буй орчноо эрүүл цэвэр байлгах дадал хэвшилд суралцуулах, ногоон хөдөлмөр эрхлэлтэд хамруулах чиглэлээр олон талт ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байна.



Нийслэлийн ногоон бүсэд ойг нөхөн сэргээх, залуучуудын нэрэмжит төгөл байгуулах, булаг шандын орчинд хамгаалалт хийж, ойн санг нэмэгдүүлэх зорилгоор “Монголоо тойрч мод тарья” хөдөлгөөнд хамрагдах хүсэлтэй, иргэн, сайн дурын бүлэг, нөхөрлөлүүдтэй дүүргүүдийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн хэлтсээр дамжуулан хамтран ажиллаж байна.

Эрүүл оюутан хөгжлийн түүчээ аян зохион байгуулсан тухай

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, халдварт өвчний тархалтыг бууруулах, оюутан, залуучуудад эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

2018-2019 оны хичээлийн жилийн оюутны эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд “Эрүүл оюутан-Хөгжлийн түүчээ” уриатай аяныг 10 дугаар сарын 22-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны хооронд зохион байгуулахаар төлөвлөж байна.

Энэ хичээлийн жилд манай улсад 96 их, дээд сургуульд нийт 156,000 оюутан суралцаж байна. Нийт оюутнуудын 92,8 хувь нь Улаабаатар хотод, 7,2 хувь нь хөдөө орон нутагт суралцаж байна.

Эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргасан мэдээллээр 2017 онд нийт 17,530 үр хөндөлтийн тохиолдол бүртгэгдсэн байна. Үр хөндөлт хийлгэж буй эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзэхэд 20-иос доош насных 5.3 хувь, 20-34 насных 70.0 хувь, 35-аас дээш насны эмэгтэйчүүд 24.7 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад 20-иос доош насны үр хөндөлтийн түвшин 0.3 хувиар өссөн байна. Мөн тухайн оны байдлаар зонхилон тохиолдох БЗДХ-тай бүртгэгдсэн тохиолдлын 59.6% нь эмэгтэй, 40.4% нь эрэгтэйчүүд байна. Насны бүлгийн хувьд 12.3% нь 15-19 нас, 26.4% нь 20-24 нас, 25.2% нь 25-29 нас, 14.8% нь 30-34 нас, 8.9% нь 35-39 нас, 12.4%-ийг 40-өөс дээш насныхан тус тус эзэлж байна.

Судалгаанаас үзэхэд Монгол Улсад нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн (15-49) дунд үр хөндөлтийн түвшин аажмаар буурч байгаа үзүүлэлт байгаа хэдий ч хэд хэдэн насны бүлэгт байдал эрс өөр байна. Энэ өсөлт ялангуяа 15-19 насны өсвөр насны охидын дунд маш өндөр, 20-35 насныхны дунд өндөр байна. (НҮТС, 2016 он)

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тодорхой зохицуулалт орсны дагуу нийт оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулахыг их, дээд сургуулийн захиргаа хариуцахаар болсон.

Тус аянаар оюутнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, сургалт сурталчилгааг зохион байгуулах, оюутны эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сурталчлах зорилготой юм.


Энэ хугацаанд оюутнуудад эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл амьдралын зан үйлийг сурталчилахад чиглэсэн сургалт нөлөөллийн ажлуудыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, нийслэлийн 9 дүүргийн эрүүл мэндийн газар, төв, Залуучуудын хөгжлийн төвүүд хамтран зохион байгуулж байна.

“Эрүүл оюутан-хөгжлийн түүчээ” оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны хооронд ХААИС, МУБИС, МУИС, ШУТИС,СЭЗИС, СУИС-ийн нийт 5061 оюутанд сургалт, нөлөөллийн ажлыг явууллаа.

Мэдээллийн технологийн салбарт мэргэшсэн залуучуудыг цагийн болон тогтвортой ажлын байранд зуучлах хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг

“Эм Кэй Ай Ти” сургалтын төвтэй хамтран мэдээлэл технологийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн болон суралцаж байгаа залуучуудыг тогтвортой ажлын байраар хангах, мэдээлэл технологийн чиглэлээр үйл

ажиллагаа явуулдаг Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллагуудад Солонгосын аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах боломж олгох зорилгоор “Мэдээллийн технологийн салбарын нээлттэй ажлын байрны өдөрлөг”-ийг



2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр “MSDI” ТББ-тай хамтран НЗХГ-ын дэргэдэх “Залуучуудын хөгжлийг дэмжих төв”-ийн байранд нийт 272 залуучуудын оролцоотой тус тус зохион байгуулав. Үүнээс 116 иргэн анкет бөглөн нөөцөд бүртгүүлэв. 1 дүгээр шатны ярилцлагад 92 залуу оролцож, 2 дугаар шатанд нийт 14 залуу тэнцэн, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН, байгууллагуудад 7 залууг ажлын байранд зуучлав.

“ГҮЙЕ!, ТҮҮЕ!” АЯН

Нийслэлийн хөгжил тохижилтод залуучуудын санаачилга, оролцоог нэмэгдүүлэх залуучууд манлайлсан хот болгох зорилгоор “Хоггүй Тэрэлж” уриатай орчноо цэвэрлэх үйл ажиллагааг 2018 оны 04-р сарын 01-ний өдөр “Гэрэлт ирээдүй” сайн дурын нэгдэл, “Налайх тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮ-ийн газар, “Brussels Belgian Beer Cafe” кафены хамт олон нийт 40 гаруй залуустай хамтран зохион байгуулж, Тэрэлжийн бүсийн Туул голын ай сав дагуу хуримтлагдсан 2 тонн хогийг цэвэрлэв.

Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/01 дүгээр захирамжаар 2018 оныг “Иргэдийн оролцоотой орчныг сайжруулах жил” болгон зарласантай холбогдуулан хүрээлэн буй байгаль орчныг хамгаалах, хоггүй хотод амьдрахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хог хаягдлаас үүдэлтэй хөрс, усны бохирдол, халдварт өвчний тархалтаас сэргийлэх зорилгоор залуучуудын сайн дурын оролцоотой “ГҮЙЕ!, ТҮҮЕ!” аяныг нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар санаачлан нийслэлийн Байгаль орчны газар, нийслэлийн Тээврийн газар болон Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар, “Монголын Бодибилдинг Фитнессийн Холбоо” ТББ-ын гишүүд, 24 байгууллагын албан хаагчид, сайн дурын иргэд нийт **1,408** хүний оролцоотойгоор 2018 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулав.

Аяны үр дүнд Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Гачууртын гүүрнээс “Гурван модны рашаан”, Маршалын гүүрнээс

Баянзүрх хайрхан, Хар усан Тохойгоос “Монгол Шилтгээн” цогцолбор хүртэл гол



дагуу тархан, хуримтлагдсан 54.2 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.

“Гүйе! Түүе!” аяны хоёр дахь удаагийн үйл ажиллагааг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 2018 оны 06-р сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Иргэдэд хог түүнгээ хөдөлгөөн хийх, хог хаяхгүй дадлыг хэвшүүлэх, олон талын ач холбогдолтой “Гүйе!, Түүе!” аяны хүрээнд зохион байгуулагдаж байгаа гурав дахь удаагийн орчноо цэвэрлэх үйл ажиллагаанд “Монголын Бодибилдинг Фитнесийн Холбоо” ТББ-ын гишүүд, 9 дүүргийн 300 сайн дурын залуучууд оролцож, 2.3 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Бодибилдинг фитнесийн “Азийн Гран При” тэмцээний ялагч болох 11 тамирчид хог цэвэрлэхэд гар бие оролцож, үлгэр дуурайл үзүүлэн, залуучуудыг уриалж байгаагаараа энэхүү үйл ажиллагаа онцлог болсон юм.

Тус аяны хүрээнд 2018 онд нийт 3 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж, нийт 1,708 иргэнийг хамруулан 56.5 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САРЫН АЯН

Дэлхийн болон Монголын залуучуудын өдрийг тохиолдуулан 2018 оны 08 дугаар сарын 15-наас 09 дүгээр сарын 15-ны хооронд Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус



байгууллагуудтай хамтран нийт 23 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж, давхардсан тоогоор 58,215 залуучуудыг хамруулсан.

НОГООН ОРЧИН, ЭРҮҮЛ АМЬДРАЛ АЯН **Нийслэлийн Залуучуудын газрын нэрэмжит** **“Зүрхэн навчис” төгөл**

Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1088 дугаар “Хөрөнгө гаргах тухай” захирамжид заасны дагуу “Зүрхэн навчис” төгөлийг Чингэлтэй дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Зүрх-Уул”-ын аманд “My club” ТББ, “7 буудал бизнес зөвлөл” ТББ, Нийслэлийн 9 дүүргийн Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнуудыг оролцуулан 2018 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 400 мод тарьж, ногоон орчинг хайрлан хамгаалах талаар сургалт зохион байгуулав.

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар “Ногоон хөгжил, цэвэр агаар-нэг мод хөдөлгөөн” ТББ-тай хамтран бүтээлч хөдөлмөрт оролцох хүсэлтэй залуучуудыг иргэдийн сайн дурын нөхөрлөл дээр тулгуурлан ногоон байгууламжийг бий болгох, цэцэрлэг, амралт зугаалгын газрыг тохижуулах, мод, бут, сөөгийг тарьж, арчлан ургуулах талаар мэргэшүүлэх сургалтыг 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Нийслэлийн засаг захиргааны V байрны сургалтын танхимд зохион байгууллаа. Тус сургалтад хамрагдсан 30 иргэн сертификат гардан авч, суралцсан чиглэлээрээ түр ажлын байраар хангагдан ажиллав.

Мөн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд байгаль орчноо нөхөн сэргээх, зохистой ашиглах, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг иргэдэд таниулан, мэдээлэл түгээж ажилладаг бөгөөд Нийслэлийн ЕБС-уудын сурагчид, их, дээд сургуулийн оюутан, залуучуудын экологийн боловсролыг сайжруулах, ногоон хөдөлмөр эрхлэлтэд хамруулах чиглэлээр олон талт ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байна.

Нийслэлийн ногоон бүсэд ойг нөхөн сэргээх, залуучуудын нэрэмжит төгөл байгуулах, булаг шандын орчинд хамгаалалт хийж, ойн санг нэмэгдүүлэх зорилгоор “монголоо тойрч мод таръя” хөдөлгөөнд хамрагдах хүсэлтэй, иргэн, сайн дурын бүлэг, нөхөрлөлүүдтэй дүүргүүдийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хэлтсээр дамжуулан хамтран ажиллаж байна.

СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ

Эерэг хандлага - Эрүүл оюутан сургалт

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, нийслэлийн 9 дүүргийн эрүүл мэндийн төв, Залуучуудын хөгжлийн төвүүдтэй хамтран “Эрүүл оюутан-хөгжлийн түүчээ” оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар ХААИС, МУБИС-ын 350 оюутнуудыг

хамруулан эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл амьдралын зан үйлийг сурталчлахад чиглэсэн сургалт нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж, нийт **10,350** оюутан залуучуудыг хамруулав.

Цэргийн алба хааж буй залуучуудад зориулсан сургалт, нөлөөллийн ажил

Цэргийн алба хааж байгаа залуучуудад эерэг сэтгэлгээний болон амьдралын суурь ур чадварыг дээшлүүлэх, хотын соёлч иргэний хандлагыг төлөвшүүлэх сургалтыг Зэвсэгт Хүчний Жанжин Штабтай хамтран зохион байгуулав.

Нийслэлийн 9 дүүрэгт байрлах Улаанбаатар хүрээний Зэвсэгт хүчний 013, 150, 032, 015, 011, 017, 084, 124, 119, 120, 326, 303, 014, 353, 337, 350, 284, 089, 310, 189, 065 дугаар цэргийн ангиудын 7000 алба хаагчдыг сургалт нөлөөллийн ажилд хамрууллаа.



Мөн Хүүхдийн урлан бүтээх төвтэй хамтарч 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа хорих 411 дүгээр анги буюу Сургалт хүмүүжлийн төвд ял эдэлж буй 15-18 насны нийт 30 насанд хүрээгүй залуучуудад “Харилцаа ба хандлага” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Цаашид Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа хорих ангиудад хүмүүжиж буй залуучуудад эерэг сэтгэлгээ, гэр бүлийн үнэ цэнэ сэдвээр сургалт зохион байгуулахаар 2019 оны ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

“Согтууруулах ундаа, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар, Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвтэй хамтран нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, их, дээд сургуулийн оюутнуудад зориулан “Согтууруулах ундаа, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2018 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс **10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 11 удаа зохион байгуулж**

1,919, нийт 41 удаагийн сургалтад 4,938 ахлах ангийн сурагчид болон оюутан, залуучууд, 18 удаагийн давтамжтайгаар 2851 ахлах ангийн сурагчдыг хамруулав.

Сургалтын үеэр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний хор уршиг, түүнээс гарах үр дагаврын талаарх мэдээллийг сурагч, оюутан, залуучуудад өгөв.

“Монголчуудын угийн бичиг” сэдэвт сургалт

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Түүхийн тэнхимтэй хамтран Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.3-т заасныг үндэслэн өсвөр үе, залуучуудад гэр бүлийн соёл, уламжлалыг дээдлэх, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх талаар мэдээлэл өгөх чиглэлээр сургагч багш бэлтгэх сургалтыг нийслэлийн есөн дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Залуучуудын хөгжлийн төвүүдийн ажилтан, албан хаагчдыг хамруулан 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдөр амжилттай зохион байгууллаа.



Сургалтад нийслэлийн есөн дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Залуучуудын хөгжлийн төвүүдийн нийт 27 ажилтан, албан хаагчид оролцсон бөгөөд Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны

Сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Түүхийн тэнхимийн багш түүхийн ухааны доктор (ph.d), дэд профессор Э.Жигмэддорж “Угийн бичгийн түүх, үүсэл, хөгжил”, багш П.Бямбахорол “Угийн бичиг хөтлөх аргачлал”, багш Л.Мөнхбаяр “Угийн бичиг хөтлөх аппликейшин, түүнийг ашиглах” сэдвүүдээр тус тус илтгэл тавьж, угийн бичиг хөтлөх гарын авлага тараан зөвлөгөө мэдээлэл өгөв.

ЧУУЛГА УУЛЗАЛТ БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

“Монгол оюун Монголын төлөө” гадаадад төгсөгчдийн нэгдсэн анхдугаар чуулга уулзалт

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар нь гадаадад их, дээд сургууль төгсөгчид болон ажиллаж хөдөлмөрлөж байсан залуучуудыг дэмжих, ажлын байраар хангах, хамтран ажиллах зорилгоор “Гадаадад Төгсөгчдийн Нэгдсэн Зөвлөл” ТББ үүсгэн байгуулагдахад нь дэмжлэг үзүүлэн, төрийн байгууллагын зүгээс хуралдаан зохион байгуулах байраар ханган, цаашид үйл ажиллагааг нь тогтворжуулах чиглэлээр хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулж, гадаадад төгсөгчдийн нэгдсэн анхдугаар чуулга уулзалт хийх ажлыг санаачлан хамтран хэрэгжүүлсэн.

“Гадаадад Төгсөгчдийн Нэгдсэн Зөвлөл” нь Монгол Улсын нийгэм, эдийн засагт гадаадын их, дээд сургууль төгсөгчдийн эрдэм мэдлэг, арга туршлагыг нэвтрүүлэх замаар хөгжил, цэцэглэлтэд бодит хувь нэмэр оруулах, хилийн чанадад ажиллаж, амьдарч буй иргэдийн эх орондоо эргэн ирж хөдөлмөр эрхлэхэд тулгардаг саад бэрхшээлүүдийг арилгах, хөнгөвчлөх зорилгоор үйл ажиллагаа явуулдаг.





Гадаадад төгсөгчдийн “Монгол оюуныг Монголын төлөө” анхдугаар нэгдсэн чуулга уулзалтын тунхаглал:

Бид, нийгмийн хөгжлийн түүчээ болж, оюун ухаанаараа манлайлагчид байж, эвлэлдэн нэгдэж чаддаг, идэвх, чармайлт, оролцоотой, эх орныхоо хөгжил дэвшилд эрдэм чадлаа зориулах, гэгээн мөрөөдөлтэй, эерэг хандлагатай, эх оронч залуучуудын нэгдэл мөн.

Гадаадад дээд боловсрол эзэмшсэн залуучуудын нэгдэл болох “Гадаадад төгсөгчдийн нэгдсэн зөвлөл” ТББ-тай хамтран Нийслэлийн Засаг даргын ивээл дор “Монгол оюуныг Монголын төлөө” гадаадад төгсөгчдийн нэгдсэн анхдугаар чуулга уулзалтыг 2018 оны 06-р сарын 30-ны өдөр Шангри-Ла төвд зохион байгууллаа.



Чуулга уулзалтаар дэлхийн өнцөг булан бүрт суралцаж, дээд боловсрол эзэмшсэн, олон талт туршлага хуримтлуулсан залуучууд эвлэлдэн нэгдэж, эх орныхоо хөгжил дэвшилд, түүний дотор нийслэл Улаанбаатар хотын хөгжилд хувь нэмрээ оруулах боломж, бололцоог хамтдаа эрэлхийлэхийн зэрэгцээ “Гадаадад төгсөгч залуучуудыг дэмжих нэгдсэн хөтөлбөр”-ийн төслийг боловсруулахаар болов.



Тус чуулга уулзалтын үеэр “Гадаадад төгсөгчдийн нэгдсэн зөвлөл” нь бусад холбоодын хамт нийслэл Улаанбаатар хотын бүхий л салбарт бодлого боловсруулах шатанд оролцож, бүтээн байгуулалтад төсөл санаачлан, хамтран ажиллах боломж бололцоог нэмэгдүүлэх талаар харилцан санал солилцсон юм.

“ЭЭРЭГ, АЮУЛГҮЙ, ХАРИУЦЛАГАТАЙ ЦАХИМ ОРЧИН” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар нь нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.1-т “Нийслэлд залуучуудын талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.” гэж тусгасны дагуу цахим орчинд эерэг хандлага төлөвшүүлж, өсвөр үе, залуучуудын дунд эерэг соёлтой, хариуцлагатай, аюулгүй хэрэглээг бий болгох зорилгоор 2018 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр 13:00-17:00 цагийн хооронд нийслэлийн Иргэний танхимд “Эерэг, аюулгүй, хариуцлагатай цахим орчин” хэлэлцүүлгийг зохион байгууллаа.



Хэлэлцүүлэгт өсвөр үе, залуучуудын төлөөлөл болсон 300 залуучууд оролцсон бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хороо, ЦЕГ-н Урьдчилан сэргийлэх хэлтэс, Нийслэлийн 9 дүүргийн ГБХЗХХ-н Залуучуудын хөгжлийн төв, Хэвлэлийн Хүрээлэн ТББ, Хэвлэл мэдээллийн зөвлөл ТББ, “ЭКО” телевиз, “Хүннү.мн” цахим мэдээллийн сайт, Залуу сэтгүүлчдийн клубүүдийн төлөөлөл хүрэлцэн ирж, илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлэв.



Хэлэлцүүлгийн үр дүнд ирсэн 300 залуучууд “Өдөр бүрийг эерэг мэдээллээр эхлүүлцгээе” уриатай “Эерэг, аюулгүй, хариуцлагатай цахим орчин-Залуучуудын оролцоо” сэдэвт 7 хоногийн аянд нэгдэж гарын үсэг зурснаар цахим орчинд эерэг, аюулгүй, хариуцлагатай орчныг хамтдаа бүтээх илч болцгоов.

Аяны мэдээ, мэдээллийг Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын албан ёсны цахим хуудаст байршуулж, нийт 6,540 удаагийн хандалт авсан байна.

Залуучуудын хөгжлийн асуудлаарх хамтын ажиллагааны гурван талт уулзалт

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар болон



НҮБ-ын Хүн амын сан хамтран залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын дундах уулзалтад 2018 оны хүрээнд 11 удаа оролцсон.

Гурван талт уулзалт нь залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагууд, төрийн байгууллагууд, НҮБ-ын болон бусад олон улсын байгууллагууд тогтмол харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах боломж олгох зорилгоор НҮБ-ын Хүн амын сан 2015 оноос дэмжиж ирсэн бүтэц юм.

Энэхүү арга хэмжээгээр залуучуудад нийтлэг тулгамддаг тодорхой асуудал болон засгийн газрын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд шийдлийг залуучууд өөрсдийн өнцгөөс тодорхойлж шийдвэр гаргахад бодитоор оролцож, хэрэгжүүлэхэд шинэлэг, бүтээлч байдлаар хамтран ажиллах юм. Судалгаа, баримт дээр суурилан олон улсын жишгээс суралцаж тухайн бэрхшээлт асуудалд хамгийн ихээр өртөж буй залуучуудын амьдралын туршлага, дуу хоолой, үзэл бодол, байр суурийг чухалчлан хэлэлцэнэ. Мөн уулзалтаас гарсан бодит санал, шийдэл, зөвлөмжийг тус тусын эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхийн төлөө ажиллахад энэхүү уулзалтын зорилго оршдог.

Нийслэлийн хүүхэд, залуучуудын байгууллагын гурван үеийнхний чуулга уулзалт

Нийслэлийн залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 95 жилийн ой, нийслэлийн хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан нийслэлийн хүүхэд, залуучуудын байгууллагын ахмад үеийн төлөөллүүдийн санаачилгыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд дэмжин “Гурван үеийн хүндэтгэлийн чуулган”-ыг 2018 оны 08 дугаар сарын 25-ны өдөр нийслэлийн Улаанбаатар чуулгад зохион байгуулав.



Нийслэлийн залуучууд, хүүхдийн байгууллагуудын үе үеийн төлөөллүүдийн залгамж холбоог сайжруулах, өв уламжлалыг сэргээн хөгжүүлэх, сайн туршлагыг нэвтрүүлэх зорилготой энэхүү анхдугаар чуулганы ерөнхий зохион байгуулагчаар нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар, “Улаанбаатар хотын эвлэл, пионерийн ахмад ажилтны зөвлөл” ТББ, хамтран зохион байгуулагчаар нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, дүүргүүдийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс болон Залуучуудын хөгжлийг дэмжих төвүүд ажилласан юм.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд “Нийслэл Улаанбаатар хотыг Монгол үндэстний хэв маяг, өвөрмөц дүр төрхтэй

зүүн хойд Азийн санхүү, бизнес, аялал жуулчлалын төв хот болгох зорилгыг 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгасан бөгөөд энэхүү үйлсэд нийслэлийн хүн амын гуравны нэгийг эзэлж буй залуучуудын оролцоо чухал тул нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газрыг 2016 онд байгуулсан юм.

Ингэснээр залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн захиргааны байгууллагатай болж, нийслэлийн хэмжээнд залуучуудыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх боломжтой болсон. Хотын хөгжил, хүний хөгжлөөс, хүний хөгжил хүүхэд, залуучуудын хөгжлөөс эхэлдэг. Иймд нийслэлийн хүүхэд, залуучуудын байгууллагад хөдөлмөр эрхэлж байсан ахмадуудаас туршлага судлах, санал солилцох зорилгоор энэхүү хүндэтгэлийн чуулганд оролцож, их түүхийг бүтээлцсэн үе үеийн хүүхэд, залуучуудын байгууллагын нийт ажилтан, албан хаагчдадаа талархал илэрхийлж, эрх зүйн хувьд бие даасан, эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэх нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн төлөө хамтдаа тэмүүлэхийг уриалсан.

“Гурван үеийн хүндэтгэлийн чуулган”-ыг угтан нийслэлийн Залуучуудын хөгжлийн газраас олон талт үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд чуулганы үйл ажиллагаа ахмад, дунд, залуу, үеийн төлөөллүүд жанжин Д.Сүхбаатарын хөшөө, Их зохиолч Д.Нацагдоржийн хөшөөнд цэцэг өргөж, Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлснээр эхэлсэн юм.



Чуулганд ахмад, дунд, залуу үеийн нийт 500 төлөөлөгч оролцож, залуучуудын байгууллагын 95, хүүхдийн байгууллагын 90 жилийн түүхийг өгүүлсэн фото зургийн үзэсгэлэнг үзэж, санал бодлоо солилцон, “Гурван үеийн хүндэтгэлийн чуулган”-ыг хааж, үе үеийн төлөөллүүд хамтран хүндэтгэлийн концертыг зохион байгуулав.

“Залуучууд Судлал 2018” Эрдэм шинжилгээний бага хурал

“Залуучууд Судлал 2018” Эрдэм шинжилгээний бага хурлыг Залуучуудын дуу хоолойг сонсох, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох зэрэг олон талын зорилгын хүрээнд зохион байгуулсан тул хуралд Санхүү Эдийн Засгийн Их Сургууль нь хамтран зохион байгуулагчийн үүрэгтэй оролцлоо.

Энэ хамтын ажиллагаа нь “Залуучуудын Хөгжлийн Газар”-тай цаашид олон ажил дээр хамтран ажиллах эхлэл болсон гэж үзэж байна. СЭЗИС нь тус бага хурлыг амжилттай зохион байгуулахад орчин нөхцөл бүрдүүлэх болон эрдэм судлалын хүрээнд хамтарч ажилласан ба дараах үүргүүдийг гүйцэтгэж ажилласан юм. Үүнд:

1. ЭШБХ зохион байгуулах танхим бэлтгэх,
2. ЭШБХ-ийн удирдамж боловсруулах,
3. ЭШБХ-ийн мэдээлэл түгээх,
4. ЭШБХ-ийн шалгаруулалтуудыг удирдан явуулах,

Дээрх хүлээсэн үүргийн хүрээнд СЭЗИС-ийн зүгээс баг гарч ажил гүйцэтгэсэн юм.

Гүйцэтгэлийн үр дүн

Нэг. Танхим бэлтгэх Зохион байгуулах анги танхимийн бэлтгэх ажлыг нэг сарын өмнөөс харилцан ярилцаж, хувилбаруудыг дэвшүүлсэн ба гэрээний дагуу танхим бэлтгэсэн. СЭЗИС-ийн Б байрны “Гэр Өргөө” буюу гэрээ хэлэлцээр, эрдмийн ажлын хурлууд болдог танхимд хурлын нэгдүгээр болон хоёрдугаар шатыг зохион явуулсан.

Хоёр. ЭШБХ-ын удирдамж боловсруулах Тус ажлыг мөн хугацааны дагуу Монгол Улсын эрдмийн ажил боловсруулах стандарт жишигт нийцүүлэн боловсруулсан юм. Боловсруулсан удирдамжаа эцэслэн сургуулиуд руу “Залуучууд Хөгжлийн Газар” албан бичгийн хамт илгээсэн.

Гурав. Мэдээлэл түгээх Тус ажлыг гүйцэтгэхийн тулд сургуулийн зүгээс оюутан залуучуудын хүчээр бүх Их, дээд Сургуулиуд руу зарын постеруудыг тараасан юм. Оюутнууд зарыг оюутнуудын хамгийн их мэдээлэл авдаг зарын талбаруудад наан байршуулсан юм.

Дөрөв. Шалгаруулалт Нэгдүгээр шат: 4 “Залуучууд судлал 2018” ЭШБХ-ийн нэгдүгээр үе шатад нийт 15 Их, дээд сургуулийн оюутнуудын 58 илтгэлийн материал хүлээн авсан.

Нэгдүгээр шатны шалгаруулалтад оролцсон сургуулиудын оролцоо Нэгдүгээр шатны шалгаруулалт 2018 оны 11-р сарын 20-ны өдрийн 09.00 цагаас 19.00 цагийн хооронд явагдлаа. Энэ шатны шалгаруулалтыг шүүгчдийн 5 хүний бүрэлдэхүүнтэй явуулсан ба шалгаруулалт урьдчилан бэлтгэсэн рубрик /үнэлгээний хуудас/-ын дагуу бүх илтгэлүүдийг шүүгч бүр уншиж танилцан, үнэлгээ өгөх байдлаар шалгаруулалтыг хийсэн болно. Шүүгчдийн бүрэлдэхүүнд СЭЗИС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, доктор, профессор З.Оюунцацрал, ШУТИС-ийн УУС-ийн эрхлэгч, доктор, профессор Б.Батболд, СЭЗИС-ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн ахлах багш, доктор Б.Идэрсүрэн, Төрийн банкны Хан-Уул салбарын захирал, JCI Leader салбар

байгууллагын санхүүч, Л.Гүнсэнмаа, СЭЗИС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн багш Т.Туул нар ажиллаа. Таван шүүгчийн дундаж үнэлгээгээр эцсийн үнэлгээ хийгдсэн. Шүүгчдийн үнэлгээний үр дүнгээр дараах 10 илтгэл хоёрдугаар шатанд шалгарав.

Шалгарсан оюутнуудын илтгэлийг онооны дарааллаар хүснэгт 1-д харууллаа.

Хүснэгт 1 Нэгдүгээр шатнаас шалгарсан оюутнуудын нэр (онооны эрэмбээр)

№	Оюутны нэр	Сургууль	Байр эзлүүлсэн байдал
1.	Ч. Дэлгэрдаваа, Б.Бүжин	МУИС	1
2.	Э.Анхбаяр, Л.Анхтүшиг	СЭЗИС	2
3.	Г.Хулан, П.Үүрийнтуяа	СЭЗИС	3
4.	Биндэръяа, Лхагвасүрэн, Оюунтунгалаг СЭЗИС	СЭЗИС	4
5.	С.Дөлгөөн, М.Бат-оргил	СЭЗИС	5
6.	Б.Нинжин МУИС	МУИС	6
7.	Х.Цогбаяр, Х.Төгсбуян	СЭЗИС	7
8.	Э.Бат-эрдэнэ, О.Отгонбаяр	МУБИС	8
9.	Ж.Анужин, Э.Намуун, О.Тэргэл	МУИС	9
10.	А.Энхмаа, А.Манчир, Ж.Золзавьяа, М.Далайцэрэн, Р.Энхтүвшин	АШУИС	10

1-р шатнаас шалгарсан оюутнуудын мэдээллийг “Залуучууд Хөгжлийн Газар”-т хүргүүлсэн ба тэндээс оюутнуудад мэдээлэл өгч, 2-р шатанд тэнцсэн болохыг мэдэгдэж, хоёрдугаар шатны зохион байгуулалтын талаар чиглүүлэг өгөв.

Хоёрдугаар шат: “Залуучууд судлал 2018” оюутны эрдэм шинжилгээний бага хурал хоёр үе шаттай явагдлаа. Тус хурлын эцсийн шатны шалгаруулалт 2018 оны 11-р сарын 22-ны өдрийн 09.00 цагт СЭЗИС-ийн Гэр-Өргөө танхимд болж, залуучуудын хөгжил, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй амьдрах орчин, хөгжих орчин сэдвээр шилдэг 10 илтгэлийг хэлэлцүүлэв. Хоёрдугаар шатны шүүгчдийн бүрэлдэхүүнд НЗХГ-ын дарга С.Сүх-Очир, СЭЗИС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, доктор, профессор З.Оюунцацрал, ШУТИСийн ТИЗСН-ийн тэргүүн, доктор Б.Чинзориг, СЭЗИС-ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн ахлах багш, доктор Б.Идэрсүрэн, Төрийн банкны Хан-Уул салбарын захирал, JCI Leader салбар байгууллагын санхүүч, Л.Гүнсэнмаа, СЭЗИС-ийн СУТ-ийн багш Г.Ариун-Эрдэнэ нар ажиллаа. ЭШБХ-ын хөтөлгөөр СЭЗИС-ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн ахлах багш, доктор Б.Амарсанаа ажиллав. Эцсийн шатны шалгаруулалтыг “Залуучууд

Хөгжлийн Газар”-ын дарга нээж үг хэлэн, хурлын модератор дэгээ танилцуулснаар 2ур шатанд шалгарсан 10 илтгэлийг хэлэлцүүлээ. Хэлэлцүүлэг нэг илтгэл 8 минутад танилцуулга, 7 минутад асуулт, хариулт, зөвлөмж өгөх байдлаар хурлын дэгээ явагдсан болно. Таван шүүгчийн дундаж үнэлгээгээр эцсийн үнэлгээ хийгдсэн. Шүүгчдийн үнэлгээний үр дүнгээр шилдэг илтгэлүүдийг шалгаруулав. Шалгарсан оюутнуудын илтгэлийг Тэргүүн байр 1, дэд байр 1, гуравдугаар байр 1, тусгай байр 3, өргөмжлөл 4 гэсэн шалгаруулалтаар хийлээ. Хоёрдугаар шатны шалгаруулалтад амжилт гаргасан оюутнуудын байр эзэлсэн байдлыг онооны дарааллаар хүснэгт 2-д харууллаа.

Хүснэгт 2 Хоёрдугаар шатны шалгаруулалтад амжилт гаргасан оюутнуудын байр эзэлсэн байдал

№	Оюутны нэр	Сургууль	Байр эзлүүлсэн байдал
1.	Э.Анхбаяр, Л.Энхтүшиг	СЭЗИС	1
2.	Г.Хулан, П.Үүрийнтуяа	СЭЗИС	2
3.	Ч.Дэлгэрдаваа, Б.Бүжин	МУИС	3
4.	С.Дөлгөөн, М.Бат-Оргил	СЭЗИС	4
5.	А.Энхмаа, А.Манчир, Ж.Золзавьяа, М.Далайцэрэн, Р.Энхтүвшин	АШУИС	5
6.	Х.Цогбаяр, Х.Төгсбуян	СЭЗИС	6
7.	Ж.Анужин, Э.Намуун, О.Тэргэл	МУИС	7
8.	Биндэръяа, Лхагвасүрэн, Оюунтунгалаг	СЭЗИС	8
9.	Б.Нинжин	МУИС	9
10.	Э.Бат-Эрдэнэ, О.Отгонбаяр	МУБИС	10

Хоёрдугаар шатны шалгаруулалтад амжилт үзүүлсэн оюунуудын илтгэлийн сэдвүүдийг дор харуулав.

Тэргүүн байр:

- Э.Анхбаяр, Л.Энхтүшиг – “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт”

Дэд байр:

- Г.Хулан, П.Үүрийнтуяа – “Залуучуудын хөдөлмөр эрхлэхэд тулгамддаг асуудал”

Гутгаар байр:

- Б.Бүжин, Ч.Дэлгэрдаваа – “Залуучуудын хөгжлийг дэмжсэн нийтлэл, нэвтрүүлгийг хэвлэл мэдээллийн байгууллагын хөтөлбөрт тусгахын үр нөлөө харьцуулсан судалгаа”

Тусгай байр:

- А.Энхмаа, А.Манчир, Ж.Золзавьяа, М.Далайцэрэн, Р.Энхтүвшин – “3 оюутан тутмын 1 нь фэйсбүүкт донтох өндөр эрсдэлтэй байна”
- С.Дөлгөөн, М.Бат-Оргил – “Их сургуулиудын нийгмийн хариуцлага болон түүнийг хүртэх оюутны хандлага”
- Х.Цогбаяр, Х.Төгсбуян – “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд дээд боловсрол нөлөөлөх нь”

Залуучуудын өмнө тулгамдаж буй асуудлын шийдлийг тодорхойлох, оюутан, залуучуудын онол, практикийн мэдлэгийг нэмэгдүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, тэдний судалгаа шинжилгээний ажлыг дэмжих, үр дүнг нь олон нийтэд таниулах, нийгэмд залуучуудын оролцоог хангах, залуучууд судлалыг хөгжүүлэх зорилготой тус эрдэм шинжилгээний бага хурал нь их, дээд сургуулийн оюутан, залуучуудын дунд нээлттэй болсон бөгөөд цаашид жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байгаагаа зохион байгуулагчид илэрхийллээ.

“Залуучууд судлал 2018” оюутны эрдэм шинжилгээний бага хурлын хоёрдугаар шатны хэлэлцүүлгийн үйл явц



“Залуучууд судлал 2018” оюутны эрдэм шинжилгээний бага хурлын шагнал гардуулах ёслолын ажиллагаа



“Залуучууд судлал 2018” оюутны эрдэм шинжилгээний бага хурлын үйл ажиллагааг хааж “Залуучууд Хөгжлийн Газар”-ын дарга С.Сүх-Очир үг хэлэв.



“Залуучууд судлал 2018” оюутны эрдэм шинжилгээний бага хурлын үйл ажиллагаанд оролцогчид, шагнал авсан оюутнуудын хамт



ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО -ХОТЫН ХӨГЖИЛД СЭДЭВТ ХАКАТОН УРАЛДААН

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.4.-т Оюутан залуучуудыг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, тогтвортой ажлын байраар хангах, нарийн

мэргэжил эзэмшүүлэх цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулна гэж заасны дагуу Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд залуучуудын идэвхи, сайн дурын оролцоог нэмэгдүүлэх, залуучууд манлайлсан ухаалаг хот болоход тэдний хувь нэмрийг татан оролцуулах, шинэ санаа, шинэлэг шийдлийг дэмжих зорилгоор “Залуучуудын оролцоо-Хотын хөгжилд” шинэ санаа шилдэг технологи шалгаруулах хакатон уралдааныг Ухаалаг Улаанбаатар /Smart UB/ сэдвийн хүрээнд нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар болон “Стартап Терминал” ХХК, “Үндэсний стартап фонд” ХХК хамтран 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 09-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулав.

Тус уралдаан 3 үе шаттай зохион байгуулагдсан бөгөөд 1-р үе шат: 2018 оны 11-р сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 06-ны өдрийн дуустал уралдаанд оролцогчдын төслийн материалыг info@nsfund.mn имэйл хаяг болон <http://www.hackathon.nsfund.mn> хаягаар хүлээн авсан.

2-р үе шат: 2018 оны 12-р сарын 07-ны өдөр шүүгчдийн бүрэлдхүүн хуралдаж материалаа ирүүлсэн нийт 24 төслийн багуудаас шилдэг 5 багийн төслийг шалгаруулан дараагийн шатанд оролцох болсон тухай багуудад мэдэгдсэн.

3-р үе шат: 2018 оны 12-р сарын 08,09-ны өдрүүдэд шалгарсан төслийн багууд 3-5 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан бөгөөд тулгамдаж буй асуудалд шийдэл боловсруулан бизнес төлөвлөгөө гаргаж, олон улсын зарчмаар хоёр хоног буюу 48 цагийн турш “Стартап терминал” ХХК-ийн бойжуулах төвд байршин, оюун ухаанаа уралдуулан шилдгээ шалгаруулав. Уралдааны сүүлийн шатанд шалгарсан шилдэг 5 багийн хамт олонд мэргэжлийн менторууд болон зочин илтгэгч нар “Нийслэл Улаанбаатар хотын залуучуудын өнөөгийн байдал, статистик тоон мэдээлэл”, “Ухаалаг Улаанбаатар /SmartUB/”, “Төр хувийн хэвшлийн түншлэл”, “Төслийг хэрхэн хөгжүүлэх вэ?”, “Хөрөнгө оруулалт хэрхэн татах вэ?” зэрэг сэдвүүдээр зөвлөгөө, мэдээлэл өгөв.

Уралдааны шилдэг 5 багаар “Смарт Зэл”, “Эко Тор”, “UB Menu”, “UB parking”, “IoT device management” багууд шалгарч, тэргүүн байранд “Смарт Зэл” багийн “Авто зогсоолын ухаалаг IoT шийдэл” төсөл шалгарч 3 сая төгрөг, дэд байранд “UB Menu” багийн “UB Menu” төсөл шалгарч 2 сая төгрөг, гутгаар байранд “IoT device 2 management” багийн “Beetle” төсөл шалгарч 1 сая төгрөгөөр шалгарсан бөгөөд шагналт байранд орсон багуудад “Стартап терминал” ХХК-аас 21 сая төгрөгтэй дүйцэхүйц хэмжээний өртөгтэй дундын оффис, орчин нөхцөлөөр хангахаар болов.

Мөн тэргүүн байранд шалгарсан багийн төсөлд хэлэлцээр хийсний үр дүнд “Үндэсний Стартап фонд” ХХК 50 сая хүртэлх төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр болсон бөгөөд шилдгээр шалгарсан багууд уралдааны дэмжигч “Golden gym”, “Mobinet”, “Biz academy” “itools” зэрэг байгууллагуудын хөнгөлөлт, урамшууллын эрхийн бичиг болон бусад дагалдах шагналуудыг хүртсэн юм.

НИЙСЛЭЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ 22 ФИТНЕСС ТӨВИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дагуу залуучуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлөөр хангах, биеийн тамир спортоор хичээллэхийг дэмжих зорилгоор “Монголын бодибилдинг фитнесийн холбоо” ТББ-тай хамтран нийслэлийн хэмжээнд нийт 22 фитнес клубүүдэд Даваа-Баасан гаригуудад 10:00-17:00 цагийн хооронд 50 хүртэлх хувийн хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх боломжийг нээсэн юм.

Цаашид залуучуудыг амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл, боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэх ААН, байгууллагуудын тоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Мөн “Ирээдүйн мистер-2018”, “Монголын Мистер-2018” 27 дахь удаагийн Улсын аварга шалгаруулах Бодибилдинг фитнесийн тэмцээнийг тус холбоотой хамтран амжилттай зохион байгуулав.



“БОДИТООР МЭДЭРЬЕ, ЭЕРЭГЭЭР ХАРЪЯ” УРИАТАЙ АЛКОХОЛГҮЙ АМЬД ХӨГЖМИЙН ТОГЛОЛТ

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар, “Цацрах эгшиг” ТББ-тай хамтран нийслэлийн “Улаанбаатар чуулга” ОНӨҮГ, мэдээллийн технологийн “Yesuimind” ХХК-ийн дэмжлэгтэйгээр 2018 оны 07 дугаар сарын 28-ны өдөр нийслэлийн Улаанбаатар чуулгын Их танхимд “Бодитоор мэдэрье, эерэгээр харъя” уриатай алкохолгүй амьд хөгжмийн тоглолтыг зохион байгууллаа.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Нийслэлийн Залуучууд” дэд хөтөлбөрийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 158 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд тус хөтөлбөрийн 2.2.4-т “Залуучуудын амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд соёл, урлагийн шинэ хамтлаг, дуучин залуучуудыг дэмжих, тэдний уран



бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулах, чөлөөт цагаа зөв боловсон, эрүүл орчинд өнгөрөөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор энэхүү тоглолтыг зохион байгуулсан.

Хорт зуршлаас татгалзахад уриалж буй тус тоглолтод поп, металл, альтернатив, панк болон рок урсгалын шинэ залуу 9 хамтлаг сайн дураараа оролцож, нийт 325 залуучууд үзэж, сонирхсон бөгөөд зорилтот бүлгийн залуучууд энэхүү тоглолтыг үнэ төлбөргүй үзсэн юм.

“ЭХ ОРОНДОО ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЦГЭЭ” ХӨДӨЛМӨРИЙН ҮЗЭСГЭЛЭН, ЯАРМАГ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.6-д “гадаадад сурч, ажиллаж хөдөлмөрлөж байсан залуучуудыг дэмжиж, ажлын байраар хангах, хамтран ажиллах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх”, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар 2017 оны 158 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Залуучууд” дэд хөтөлбөрийн 3.2.7-д “гадаад болон дотоодод сурч боловсрон, нарийн мэргэжил эзэмшсэн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах” зорилтууд тусгагдсан.



Тус зорилтуудын хүрээнд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар нь Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ) ТББ, “Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл” ТББ, “Гадаадад Төгсөгчдийн Нэгдсэн Зөвлөл” ТББ, хүний нөөцийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Шинэ хөгжлийн түлхүүр” (MSDI) ТББ-уудтай хамтран тус хөдөлмөрийн үзэсгэлэн, яармагийг 2018 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр МҮХАҮТ-ын Их танхимд зохион байгууллаа.

Гадаадад боловсрол эзэмшиж, хөдөлмөр эрхэлж байсан залуучуудыг эх орондоо хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэн, шинэ санаа, технологийг нутагшуулах зорилготой “Эх орондоо хөдөлмөр эрхэлцгээ” хөдөлмөрийн үзэсгэлэн яармагт үндэсний тэргүүлэгч 60 аж ахуй нэгж, байгууллагуудын 2000

ажлын байр зарлаж, хүний нөөцийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг 6 байгууллага ажил хайж буй залуучуудад зөвлөгөө, мэдээлэл өгсөн юм.



Мөн энэ үеэр эх орондоо хөдөлмөр эрхлэх боломж ба тулгамдаж буй асуудлаар зохион байгуулагч байгууллагуудын төлөөллүүд мэдээлэл хийж, нээлттэй ярилцлага өрнүүлэн, гадаадад төгсөгчид болон хилийн чанадад амьдарч буй иргэд эх орондоо эргэн ирэхэд хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөл байдлын талаар залуучуудтай харилцан санал солилцов. “Эх орондоо хөдөлмөр



эрхэлцгээ” хөдөлмөрийн үзэсгэлэн яармагт нийт 1000 гаруй иргэд оролцсон юм.

Хамтран зохион байгуулагч:

"Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл" ТББ нь 39 улсад үйл ажиллагаа явуулдаг 158 төрийн бус байгууллагын төлөөллийг нэгтгэн, эх орныхоо хөгжил, гадаад сурталчилгаанд нэгдсэн бодлогоор хувь нэмэр оруулж, төрийн байгууллагуудтай нэгдсэн сувгаар харилцаж, хамтран ажиллах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Тус хөдөлмөрийн үзэсгэлэн

яармагт "Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл" ТББ-ын гишүүд, төлөөлөгчид оролцсон юм.

"Гадаадад Төгсөгчдийн Нэгдсэн Зөвлөл" ТББ нь 8 улсын гадаадад их, дээд сургуульд төгсөгчдийн холбоог нэгтгэн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус холбоодын гишүүд хөдөлмөрийн үзэсгэлэн яармагт оролцлоо.

"Шинэ хөгжлийн түлхүүр" (MSDI) ТББ нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дээр 2013 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 120 гаруй аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тус байгууллага нь ажилд холбон зуучлахаас гадна хүний нөөцийн чиглэлээр сургалт, аутсорсинг, аудитын үйлчилгээг үзүүлдэг.

Үр дүн:

"Эх орондоо хөдөлмөр эрхэлцгээе" хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг нь гадаадад төгсөгч залуучуудад эх орондоо хөдөлмөр эрхлэх, боломж байгаа талаар таниулан, сурталчилж, төрийн болон хувийн хэвшлийг мэдлэгтэй, чадвартай боловсон хүчнээр хангах, тухайн улсын шалгарсан туршлагыг нийслэл Улаанбаатар хотын бүтээн байгуулалт, тохижилтод нэвтрүүлэх, суралцсан, ажилласан орныхоо чадварлаг боловсон хүчин, мэргэжилтэн, түншүүдийг шаардлагатай төрийн болон хувийн хэвшлийн салбарт холбож, гүүр болсноор хамтын ажиллагааг өргөжүүлэх, соёлын давуу талыг нийгмийн харилцаанд нэвтрүүлж, бусдад сайн жишээ үзүүлэх ач холбогдолтой юм. Тус хөдөлмөрийн үзэсгэлэн яармагт 1,115 залуучууд оролцож, 570 иргэн нөөцөд бүртгүүлэн, 70 залуу ажилд орлоо.



АЖЛЫН БАЙР ЗАРЛАСАН АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГУУД		
Жаргал Кашмер ХХК	Тийсс Монголиа	Bodi Insurance
Халх Монгол	МАК	BSB
Монтс	Сэрүүлэг дээд сургууль	Говь
Цэцээ гүн	Таван Богд Фүүдс	MNB World

Анарваан	Номадс Hospitality	TDB
Premium palace	SERJ international	Promotrade LLC
Ekimino kindergarden	Шангри-Ла Улаанбаатар	Шинэ сонголт
Lamancel brothers	Ард даатгал	Мобиком
Тэнгэр даатгал	Эрдэнэс таван толгой	Wagner Asia
Гоёо Кашмер	Манду хаус	Шунхлай
Бишрэлт Холдинг	Нано интернэйшнл	Анун
Бишрэлт Интернашнл	Орчлон констракшн	Air Trans
Бишрэлт Trade	Юни мэд интернэйшнл	Таван Богд групп
АПУ	Ази Фарм	МТ групп
Дархан Минж	Deliotte	Bridge Group
Mon Road	Central Express	Hera Holding
M oil Group	УВ Гурил	Moncon Group
Дашваанжил	Эко Алт	Их Говь Энержи
Тесо	Алтай Хүдэр	Monnis Групп
МайнсАп	Хүнс Экспресс	Хөх Чоно Групп
ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР ЗӨВЛӨГӨӨ ҮЗҮҮЛДЭГ БАЙГУУЛЛАГУУД		
MSDI ProHRConsulting		Олон Улсын Хүний Нөөцийн Хөгжлийн Академи
Шинэ Хөгжлийн Түлхүүр	King Consulting	ORP consulting



“АВТОМАШИНГҮЙ ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭХЭД ОРОЛЦОВ

Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/861 дүгээр захирамжаар 2018 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 07:00-17:00 цагийн хооронд “АВТОМАШИНГҮЙ ӨДӨР”-ийг тэмдэглэн өнгөрүүллээ.

“Автомашингүй өдөр” нэгдсэн үйл ажиллагаанд нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар нь 12:45-15:00 цагийн хооронд жанжин Сүхбаатарын талбай дээр “Хоггүй Улаанбаатар хот – Нэг хог, нэг чихэр” хөгжөөнт тоглоом, нийслэлийн Соёл урлагийн газар, Замын цагдаагийн албатай хамтран “АХА” асуулт хариултын тэмцээн, Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төвтэй хамтран дугуйн парадыг тус тус зохион байгуулав.

Тус үйл ажиллагаануудад нийт 300 орчим иргэд, хүүхэд залуучууд оролцож “Автомашингүй өдөр”-ийг



тэмдэглэн өнгөрүүлэв.

НИЙСЛЭЛИЙН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРААС ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ТҮГЭЭСЭН БАЙДАЛ


“Эерэг амьдарцгаая” цуврал нэвтрүүлэг

Залуучуудыг соён гэгээрүүлэх, хотын соёлд суралцуулах зорилгоор 40 минутын хугацаатай нийт 24 цуврал нэвтрүүлгийг “Биг лайне фильм” ХХК-тай хамтран бүтээж, цахим сүлжээнд байршуулав.

YouTube

эерэг амьдарцгаая

Q



ЭЕРЭГ АМЬДАРЦГААЯ Дугаар 03 Замын хөдөлгөөний соёл


“Их хотын соёл” сэдэвт цуврал радио нэвтрүүлэг

Гэр бүлийн радио 104,5-тай хамтран “Их хотын соёл” сэдэвт цуврал 24 нэвтрүүлэг бэлтгэн 6 сарын турш 7 хоног тутам олон нийтэд түгээсэн.



“Их хотын соёл” сэдэвт цуврал телевизийн нэвтрүүлэг

VTV болон Star телевизүүдтэй хамтран “Их хотын соёл” сэдэвт соён гэгээрүүлэх нэвтрүүлэг бэлтгэж, тус телевизүүд олон нийтэд хүргэсэн.



Телевизийн хэлэлцүүлэг, нэвтрүүлэг

Ийгл, Эх орон, Монгол HD, Star, VTV, болон Монголын Үндэсний Олон Нийтийн телевизүүдийн хэлэлцүүлэг, нэвтрүүлэг, мэдээний хөтөлбөрийн зочны цаг буланд оролцож, нийслэлийн Залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулж буй үйл ажиллагааныхаа талаар болон эерэг хандлага, нийслэлийн иргэний дагаж мөрдөх 10 зөв дадлын тухай мэдээллийг олон нийтэд хүргэсэн.

Цахим мэдээллийн сайтад байрлуулсан мэдээ, мэдээлэл

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар нь хамгийн олон хандалттай цахим мэдээллийн хэрэгсэлд үйл ажиллагааныхаа талаар мэдээллийг цаг алдалгүй байршуулснаар залуучуудад бодит мэдээллийг шуурхай хүргэн, тэдний оролцоог хангасан үйл ажиллагааг өргөн цар хүрээтэй зохион байгуулж, 2017 онд 2500, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 480 удаагийн давтамжтайгаар олон нийтэд мэдээ, мэдээллийг хүргэсэн юм.

Мэдээ, мэдээлэл түгээсэн цахим мэдээллийн хэрэгслүүд: ulaanbaatar.mn, ikon.mn, news.mn, medee.mn, gogo.mn, olloo.mn, zindaa.mn, montsame.mn, unen.mn, setguulch.mn, eagle.mn, zaluu.mn, mgl.mn, unuudur.mn, top.mn,



itoim.mn, polit.mn, wikimon.mn, mass.mn, time.mn, times.mn, arslan.mn, eren.mn, dnn.mn, bataar.mn, mnb.mn, ehsurvalj.mn, zasag.mn, leaders.mn, updown.mn, zugeer.mn, saak.mn, uz.mn, shuud.mn, dardas.mn

“ХӨДӨЛМӨРЧ ЗАЛУУЧУУД” ХӨДӨЛМӨРИЙН ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.7.1-т “Нийслэлийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 60 хувьд хүргэнэ”, 4.7.5. “залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг дэмжин, ажил олгогч, ажил хайгч иргэдэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг нэг цэгээс үзүүлнэ”, “Нийслэлийн Залуучууд” дэд хөтөлбөрийн 3.2.7-д “Гадаад болон дотоодод сурч боловсрон, нарийн мэргэжил эзэмшсэн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах” зорилтууд тусгагдсан.

Дээрх зорилтуудын хүрээнд нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар санаачлан нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтран “Хөдөлмөрч залуучууд” ажлын туршлагагүй залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөдөлмөрийн

үзэсгэлэн яармагийг 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд зохион байгуулав.



Ажил идэвхтэй хайж байгаа хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг сурган ажлын байранд холбон, ажилд ороход шаардлагатай зөвлөн туслах үйлчилгээнд хамруулж, аж ахуй нэгж, байгууллагад холбох зорилгоор “Хөдөлмөрч залуучууд” хөдөлмөрийн үзэсгэлэн яармагт “Карьер хөгжлийн төв”, “ОРР” институт, Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн оролцож, үйл ажиллагааны чиглэлийнхээ дагуу ажил хайгч иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээ.

Тус үйл ажиллагааны үеэр нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв 2300 гаруй ажлын байранд иргэдийг бүртгэж, ажлын байранд холбосноос гадна 23 ажил олгогч байгууллага ажлын туршлагагүй залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллах боломжтой 600 гаруй ажлын байрыг нээлттэй зарласан юм.



Хөдөлмөрийн үзэсгэлэн яармагт нийт 300 гаруй иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн бөгөөд 98 иргэн ажлын байранд бүртгүүлэн, анкет бөглөж, ганцаарчилсан зөвлөгөөнд 25 иргэд хамрагдав.

Энэхүү хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг ажлын туршлагагүй залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийслэлийн хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш

оролцоог хангах зорилгоор төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран, хувийн хэвшлийнхний оролцоотойгоор зохион байгуулав.



Үйл ажиллагаанд оролцсон ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагуудын жагсаалт:

- “Таван богд групп” ХХК
- “Ич крем” ХХК
- “Эргэл хас” ХХК
- “Кашмер холдинг” ХХК
- “Траст трейд” ХХК
- “Монхангай групп” ХХК
- “М Жи Си стар групп” ХХК
- “Хөгжил трейд” ХХК
- Соёл велнес төв
- “Алтангадас трейд” ХХК
- “Ханбүргэдэй” ХХК
- Тесо Корпораци
- “Арж капитал” ХХК
- “Номин холдинг” ХХК
- “Нэкст групп” ХХК
- “Бишрэлт Трейд” ХХК
- “Тоба маркет” ХХК
- “Сэрж Интернэшнл” ХХК
- “Бишрэлт пропертис” ХХК
- “Транс капитал” ББСБ
- “ZIP сервис” ХХК
- “Наран трейд” ХХК
- “Монголын алт групп” ХХК

“НИЙСЛЭЛИЙН ШИЛДЭГ ЗАЛУУ-2018” алдаршуулах ёслолын үйл ажиллагаа

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20.1.5, “Нийслэлийн Залуучууд” дэд хөтөлбөрийн 3.2.9-д тус тус заасныг үндэслэн Монгол Улсын хөгжил дэвшил, залуу үеийг хөгжүүлэх үйл хэрэгт хүч чадал, оюун ухаан, авьяас билгээ зориулж, залуучуудын хөгжлийн талаар баримтлах бодлого, үйл хэрэгт үр бүтээлтэй оролцож, хөдөлмөрлөж байгаа, нийгмийн сайн сайхны төлөө сайн дураар ажиллаж буй залуучууд, залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр ажиллаж байгаа байгууллагуудыг алдаршуулах зорилгоор 2018 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 18:30-23:30 цагийн хооронд “Нийслэлийн шилдэг залуу-2018” алдаршуулах ёслолын үйл ажиллагааг “Баянгол зочид буудал” ХК-ны Баянгол ресторанд амжилттай зохион байгуулав.



Энэхүү үйл ажиллагааг нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Залуучуудын хөгжлийн газар 2 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж байгаа бөгөөд нийслэлийн залуучуудын хөгжлийг дэмжигч байгууллагын төлөөллүүд, хүндэт зочид, шилдэг залуучууд нийт 250 хүн оролцлоо.



Үйл ажиллагааг нээж нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын дарга Содномцогийн Сүх-очир, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэд дарга Болдбаатарын Халиун нар үг хэлж,

мэндчилгээ дэвшүүлэв. Мөн дуучин СТА, Н.Наранчимэг, Д.Хишигбаяр, Р.Дэлгэрмаа, СТА, Х.Батболд, поп дуучин, СТА Б.Баярцэцэг, амьд хөгжмийн “UB night” хамтлагууд ая дуугаа өргөж, “Авьяаслаг монголчууд” шоуны шилдэг оролцогч “Hobby dance” хамтлаг шилдэг үзүүлбэрээ үзүүлж сонирхууллаа.



Үйл ажиллагааны үеэр Монгол Улсын хөгжил дэвшил, залуу үеийг хөгжүүлэх үйл хэрэгт хүч чадал, оюун ухаан, авьяас билгээ зориулж, залуучуудын хөгжлийн талаар баримтлах бодлого, үйл хэрэгт үр бүтээлтэй оролцож, хөдөлмөрлөж байгаа, нийгмийн сайн сайхны төлөө сайн дураар ажиллаж буй шилдэг 51 залууд “Нийслэлийн Шилдэг Залуу” хүндэт тэмдэг, залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр ажиллаж байгаа шилдэг 12 байгууллагад “Залуучуудын хөгжлийг дэмжигч шилдэг байгууллага-2018” цомыг гардуулж, алдаршуулав.





	Овог, нэр	Он, Сар, Өдөр	Цаг	Гарын үсэг
Хянасан	Д.Доржхорол			
Хянасан	Н.Мандуул			
Боловсруулсан	Н.Хангайцэцэг			
Боловсруулсан	Г.Золбоо			
Боловсруулсан	Ц.Батжаргал			

--- о о 0 о о ---